

United Nations Conference on Trade and Development

National Workshop on

Fostering Integration of the Mongolia Downstream Value Chain of Meat into Regional Value Chains

29 January 2021, Ulaanbaatar, Mongolia

**Махны салбарын хөгжил ба хамтын ажиллагаа
(Meat Sector Development and Cooperation)**

By

P. Сансармаа (R. Sansarm), Trust Trade Premium Meat Products

The views expressed are those of the author and do not necessarily reflect the views of UNCTAD.



Махны салбарын хөгжил ба хамтын ажиллагаа Р.САНСАРМАА

АГУУЛГА

- Махны салбарын оролцогч талууд, хамтын ажиллагаа
- Үйлдвэрлэл, худалдааны эрүүл ахуйн нөхцөл байдал
- Махны салбарын бүтээмжийг өсгөх боломжууд
- Экспортын шаардлага, бэрхшээл, боломжууд
- Нэмүү өртөг буюу үнэ цэнийн бодлого
- Дүн шинжилгээ
- Санал, асуулт

Оролцогч талууд-хамтын ажиллагаа

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль. Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах зарчим

5.1.5.төр, иргэн, хуулийн этгээдийн хамтын үйл ажиллагаанд тулгуурлах.



Оролцогч талууд-хамтын ажиллагаа

Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засгийн, ХАА-н салбарын хөгжлийн, байгаль орчны зорилтуудад салбарын хөгжлийн чиг хандлага тодорхойлогдсон.

- Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн хөтөлбөр 2019-2023
- Эрчимжсэн мал АА-г дэмжих үндэсний хөтөлбөр 2019-2023
- МАА-н салбарын Хууль эрхзүйн орчин сайжирч,/мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, малын генетик, нөөцийн тухай хуулиуд хэрэгжсэн/ 2020 оноос мал эмнэлэгийн болон татварын системн бүртгэлжүүлэлт эхэлсэн.

Оролцогч талууд-хамтын ажиллагаа

- Төрийн бодлогыг уялдаатайгаар мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх, малчдыг мал эмнэлэгийн болон татварын системд бүртгэгдсэн мэдээлэлээр хангах, нөхцлийг олгох
- Малын тоо толгойн биш чанарын үзүүлэлтээр идэвхижүүлэх, урамшуулах бодлого боловсруулах
- Кластерын хөгжлийг дэмжих бодлого боловсруулах /малчид зөвхөн малын маллагаа, арчилгаанд төвлөрдөг/ мал эмнэлэгийн үйлчилгээ, өвс тэжээл бэлтгэл, тээвэрлэлт, түгээлт, борлуулалтын ажилд малчдын оролцоог бууруулах/

Оролцогч талууд-хамтын ажиллагаа

- Малын бүх төрлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх тарилга вакциныг үнэ төлбөргүй болгож, бүртгэлээр хянах баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх
- Бэлчээр ашиглалтын хууль, төлөвлөгөө, хөтөлбөртэй болох
- Бэлчээрийн болон фирмийн хосолмол АА эрхлэлтийг төрийн бодлогоор бодитойгоор дэмжих урамшуулах /татвараас чөлөөлөх, хүүгийн хөнгөлөлттэй нөхцлөөр зээлжүүлэх, эрсдлийн 40-өөс дээш хувийг төрөөс санхүүжүүлэх /

Оролцогч талууд-хамтын ажиллагаа

Тээвэр ложистик

- Аймгуудын төвийг Нийслэл болон бусад аймгуудтай хатуу хучилттай замаар холбосон ч 2021-2030 оны зорилтод сумдаас МАА-н тээвэрлэлтийн маршрутууд бага тусгагдсан
- Мал сүргийг тарга тэвээрэг алдуулалгүй аймаг, сумын төвд туувраар төвлөрүүлэх, нэгдсэн байдлаар бүртгэл хяналт хийн тээвэрлэх нөхцөл бүрдүүлэх
- Мал, махны худалдааг биржээр дамжуулан хийх хууль эрхзүйг хэрэгжүүлэх, туршилт хамтын ажиллагааг эхлүүлэх
- Зориулалтын тээврийн хэрэгслээр мал болон махыг тээвэрлэх зохицуулалт бүхий “Махны техникийн зохицуулалт” -ыг яаралтай хэлэлцүүлж батлуулах

Үйлдвэрлэл-Хүнсний эрүүл ахуй

Дотоодын зах зээлд тн мах хэрэглэж байгааг судалгаанд дурдсан. Үүнээс хээрийн буюу гар аргаар нядалгаа хийсэн мах байгаа. Үүнээс үүдэлтэй доорхи аюулууд үүсдэг

- Өвчтэй, туранхай малыг малчны хотонд төхөөрснөөс малын эмийн үлдэгдэл, зооноз болон халдварт өвчтэй малын мах зах зээлд нийлүүлэгдэх
- Эрүүл ахуй, аюулгүй байдлын наад захын шаардлага хангахгүй чулуу, шороо, үс, хатсан цус зэрэг физик бохирдол, хими, биологийн бохирдол, аюул үүссэн байдаг.
- Үйлдвэрийн бус аргаар нядалсан махыг нийтийн худалдаанд гаргахгүй зохицуулалтаа яаралтай хэрэгжүүлэх

Бөөний худалдаа- Эрүүл ахуй

Малчдын төвлөрсөн захуудад махаа өгөх сонирхолтой байдаг нь доорхи шалтгаануудтай.

- Үйлдвэрүүд тээвэрлэлтийн стандарт нөхцлийг шаарддаг боловч малчдын тээврийн хэрэгсэл зориулалтын бус байдаг.
- Үнэ тодорхойгүй байдлаас шалтгаалан сум, орон нутгаас гарал үүслийн болон шинжилгээний бичиг шивүүлэхдээ аль 1 захын нэр бичүүлж авдаг.
- Үйлдвэрт өгвөл сүлжээгээр дамжуулан татвар төлөх болдог, захад бол тухайн захын түрээс, хураамж төлдөг.
- Зах болон үйлдвэрлэл эрхлэгчдийн тэнцвэргүй нөхцлийг судлан шийдвэрлэх

Үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөх

- Нядалгааны үйлдвэрийг “Зөвшөөрлийн тухай хууль”-иар тусгай зөвшөөрөл олгож нээхээр болж байгаа нь хүнд суртлын шат дамжлагыг нэмэгдүүлж байгаа.
- ОУ-ын холбогдох стандарт шаардлага болон төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий 27 байгууллагын стандарт, холбогдох хуулийг хэрэгжүүлэхэд хангалттай.
- Малыг мах болгон хувиргах анхдагч үйлдвэрлэл нь дотоодын зах зээл дээр дэмжигдэн хөгжиж байж экспортын шаардлага хангана.

Үйлдвэрлэл-Эрүүл ахуй

ХБАБХТхуулийн 7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:

- Хуулийн заалтууд жигд хэрэгжихгүй 5-6 жил болж байгаа нь үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжил, экспортын шаардлага хангалтад сөргөөр нөлөөлж байна.
- Алсын хараа 2050-ын 2021-2030 онд НАССР тогтолцоог хүнс үйлдвэрлэгч бүр ханган баталгаажуулахаар заасныг аль болох яаралтай ХБАБХТ хуульд өөрчлөлтөөр оруулах

Экспортын шаардлага, боломжууд

Судалгаагаар МУ-аас экспорт хийхэд хамгийн тохиромжтой 5 улсыг нэрлэсэн нь талархуштай байна.

ОХУ болон Казакстан нь Гаалийн Холбооны Улсуудын экспортын шаардлагын дагуу аудит хяналт хийдэг. Өнгөрсөн 2-3 удаагийн хяналтаар манай улсын мал эмнэлгийн тогтолцоог шаардлага хангахгүй гэж дүгнэсэн байдаг.

БНВУ-д мах экспортлох эрх бүхий 5 компани байдаг боловч тээвэр ложистик болон ЗГ хоорондын эцсийн тохиролцоонууд хийгдээгүйн улмаас экспорт зогсонги байдалд байгаа.

Япон улс нь манай улсаас адууны мах гол төлөв импортолдог. МУ-аас татваргүй импортлох барааны жагсаалтад үхрийн өөхөн тосыг оруулсан боловч манай талаас хянан баталгаажилт, 2 талын хэлэлцээр хийлгээгүй байгаа.

Экспортын шаардлага, боломжууд

БНХАУ-руу адууны махыг түүхийгээр, үхэр хонь, ямааны махыг дулааны боловсруулалт хийгдсэн байдлаар экспортолж байгаа.

Гэвч дулааны боловсруулалт хийгдсэн махны хэрэглэгч нь хязгаарлагдмал, борлуулалт бага байдаг.

Мөн дулааны аргаар экспорт хийх зөвшөөрөлтэй ААН-ын тоо хангалттай ч нядалгааны зөвшөөрөгдсөн үйлдвэр 5 байгаа нь экспортын хэмжээ болон хугацаанд сөрөг үр дагавартай.

Цаашид БНХАУ руу хүнсний зориулалтын өөхөн тос, ясны гурил, ясны тос экспортлох нь байгаль орчинг хамгаалах болон махны үнэ цэнийг өсгөхөд хувь нэмэртэй.

Дүн шинжилгээ санал

- Одоогоор экспортонд гарч буй адууны мах, төлөгний мах /Иран улс/ зэргийг тасралтгүй бэлтгэн нийлүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах
- Мал сүргийн бүтэц, тоо хэмжээг орон нутгийн онцлог, бэлчээрийн даацтай уялдуулан экспортод чиглүүлэн төлөвлөж, нэгдсэн мэдээлэл, уялдаагаар хангах
- Малаас гарах гулууз махнаас бусад төрлийн бүтээгдэхүүн түүхий эдийн экспортод анхаарал хандуулах
- Мал эмнэлэгийн сэргийлэлт, хяналтын тогтолцоог зах хязгаар сумдад ч хүртээмжтэй байдлаар зохион байгуулах судалгаа арга аргачлалыг хэрэгжүүлэх

Дүн шинжилгээ санал

- Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын ОУ-ын шаардлагад нийцсэн бодлого хууль эрхзүйн орчинг бүрдүүлж, оролцогч талууд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- НҮБ-ын худалдаа хөгжлийн бага хурал (United Nations Conference on Trade and Development) аас хэрэгжүүлж буй төслийн судалгаа, зөвлөмжийг бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх
- Махны өртгийн гинжин хэлхээг оролцогч болгоноор жигд анхаарал хандуулан сайжруулж, мал махны үнэ цэнийг дотоод гадаадын зах зээлд өсгөх

Санал, асуулт





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!

